

*Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны
... дугаар сарын ... –ны өдрийн... дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт*

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭХ ДҮРЭМ

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг зүйл

1.1. Зорилго, үйлчлэх хүрээ

1.1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Монгол Улсын Автотээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд зорчигч тээврийн үйлчилгээний нийтлэг зарчимд тулгуурлан зорчигч, зорчигчийн тээш, **илгээмжийн** ачааг аюулгүй, шуурхай тээвэрлэхэд оршино.

1.1.2. Энэхүү дүрмээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр автотээврийн хэрэгслээр зорчигч тээврийн ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага /цаашид “тээвэрлэгч” гэх/, тээврийн үйлчилгээг хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн /цаашид “тээвэрлүүлэгч” гэх/, зорчигч тээврийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, удирдлагаар хангах чиг үүрэг бүхий байгууллагад тавигдах шаардлага, хүлээх эрх, үүргийг тодорхойлж, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.1.3. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгслээр зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж буй гадаад улсын хуулийн этгээд, иргэн энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

1.1.4. Энэхүү дүрэмд хэрэглэгдсэн нэр томъёо, тодорхойлолтыг Монгол Улсын Автотээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5012:2011, “Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS5122:2013, “Жуулчны автотээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5231:2003 Монгол Улсын стандартууд болон “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт” БД 32-101-17 барилгын дүрэмд тус тус заасан утгаар ойлгож хэрэглэнэ.

Хоёрдугаар бүлэг. Зорчигч тээврийн үйлчилгээний ангилал

2.1. Зорчигч тээврийн үйлчилгээг дараах байдлаар ангилна.

2.1.1. зорчигчийн тогтмол тээвэр;

2.1.2. зорчигчийн тогтмол бус тээвэр.

2.2. Зорчигчийн тогтмол тээвэрт нийтийн тээвэр (автобус, таксийн үйлчилгээ), зорчигчийн тогтмол бус тээвэрт жуулчин тээвэр, бусад зохион байгуулалттай гүйцэтгэх захиалгат үйлчилгээ (хүүхэд тээвэрлэх, байгууллагын ажилчид тээвэрлэх, иргэд, байгууллагын захиалгаар хийх тээвэрлэлт) хамаарна.

2.3. Зорчигч тээврийг үйлчлэх хүрээгээр нь дор дурдсанаар ангилна.

2.3.1. хотын доторхи зорчигч тээвэр;

2.3.2. хот орчмын зорчигч тээвэр;

2.3.3. хот хоорондын зорчигч тээвэр;

2.3.4. орон нутгийн зорчигч тээвэр;

2.3.5. улс хоорондын зорчигч тээвэр

Гуравдугаар бүлэг. Зорчигч тээврийн үйлчилгээний зохион байгуулалт

3.1. Нийтлэг шаардлага

3.1.1. Зорчигч тээврийн үйлчилгээнд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр болон Үндэсний хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг дагаж мөрдөнө.

3.1.2. Тээвэрлэгч нь Иргэний хууль болон Автотээврийн тухай хуульд нийцсэн тээвэрлэлтийн гэрээг тээвэрлүүлэгчтэй байгуулсны үндсэн дээр зорчигч тээврийн үйлчилгээг гүйцэтгэнэ.

3.1.3. Тээвэрлэгч нь “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5012:2011 Монгол Улсын стандартад заасан шаардлагыг бүрэн хангасан байна.

3.1.4. Тээвэрлэгч нь үйлчилгээний нөхцөл, тээвэрлэгч-жолоочийн үйлчилгээнд гарах, буух, түр зогсох нөхцөл, шалгагч механик ба диспетчер инженер, засварын инженер, техникийн ажилчдын ажлын нөхцлийг багтаасан технологийн картыг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэн ажиллана.

3.1.5. Зорчигч тээврийн хэрэгсэл нь зорчигчдын ая тухтай, аюул осолгүй зорчих, аялах нөхцөл бүрдсэн, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын хувьд аюулгүй, "Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд тавих шаардлага" MNS 4598: 2011 стандартад заасан шаардлагыг бүрэн хангасан байна.

3.1.6. Зорчигч тээврийн хэрэгсэл нь Стандарт хэмжил зүйн газраас баталгаажуулсан бүртгэл, мэдээлэл, хяналтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

3.1.7. Зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж буй жолооч нь хөдөлмөр, амралтын горимыг холбогдох хууль тогтоомжийн дагуу мөрдөж ажиллана.

3.1.8. Зорчигч тээврийн үйлчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, шинжилгээний арга, аргачлалын үндсэн дээр төлөвлөнө.

3.1.9. Хотын доторхи болон хот орчмын, аймгийн төвийн доторхи зорчигч тээврийн үйлчилгээг хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулах замаар тухайн бүсэд амьдарч буй оршин суугчдын тээврийн эрэлт хэрэгцээнд үндэслэн зорчигч урсгалын хэмжээ, замын зорчих хэсгээр нэвтрэн өнгөрөх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний давтамж, замын нөхцөл байдал, нэвтрүүлэх чадварыг судлан үзсэний үндсэн дээр төлөвлөнө.

3.1.9. Улс, хот хооронд, аймаг, сумдын хооронд хийгдэж буй зорчигч тээврийн төлөвлөлтийг автобусны зардал, үр ашгийн тооцоог хийсний үндсэн дээр төлөвлөнө.

3.1.10. Зорчигч тээврийн үйлчилгээний зөвшөөрөгдсөн чиглэлд автобусны зардал, үр ашгийн тооцоо, холбогдох судалгааг хийлгүйгээр өөрчлөлт оруулахгүй.

3.1.11. Автотээврээр гүйцэтгэж буй зорчигч тээврийн үйлчилгээг төмөр зам, агаарын тээврийн зорчигч тээврийн үйлчилгээтэй уялдуулан зохион байгуулна.

3.2. Нийтийн тээвэр /автобусны үйлчилгээ/

Тээвэрлэгч нь дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

3.2.1. Улс хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг олон улсын гэрээ, Олон улсын автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд оролцогч талуудын эрх бүхий байгууллага хоорондын хэлэлцэн тохиролцсон чиглэл, зураглал, цагийн хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

3.2.2. Улс хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч нь өмнө нь хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг гурваас доошгүй жил эрхэлсэн ажлын туршлагатай байна.

3.2.3. Таксинаас бусад нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг урьдчилан тогтоосон замнал, цагийн хуваарийн дагуу зохицуулна.

3.2.4. Нийтийн тээврийн үйлчилгээний цагийн хуваарь нь зорчигчдоос бага хугацаа зарцуулж, ая тохитой, аюулгүй зорчих нөхцөл, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, жолоочийн хөдөлмөрийн хэвийн нөхцөл, автотээврийн хэрэгслийг оновчтой ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.

3.2.5. Нийтийн тээврийн үйлчилгээ (автобусны)-нд ажиллах жолооч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.2.5.1. “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2011 Монгол Улсын стандартын хүний нөөцийн хөгжилд тавих шаардлагыг бүрэн хангасан байх;

3.2.5.2. үйлчилгээнд гарахын өмнө тээврийн хэрэгслийн техникийн ерөнхий үзлэг хийж, техникийн аюулгүй байдлыг шалгагч механик болон диспетчер инженерээр шалгуулна.

3.2.5.3. үйлчилгээнээс буухдаа тээврийн хэрэгсэлд шаардлагатай түлш, тослох материалыг авч, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг шалгагч механик болон диспетчер инженерээр шалгуулна. Шалгасан тухай тэмдэглэл хөтөлж, баталгаажуулна.

3.2.5.4. хэрэв үйлчилгээнд гарах тээврийн хэрэгсэл нь техникийн аюулгүй байдал болон тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаагүй бол үйлчилгээнд гаргахгүй.

3.2.5.5. үйлчилгээнд гарахын өмнө замын хуудсыг авах ба үйлчилгээнээс буухдаа замын хуудсыг шалгагч механик болон диспетчер инженерээр шалгуулж, баталгаажуулна.

3.2.5.6. үйлчилгээний явцад жолооч нь тээврийн хэрэгслийн техникийн болон хөдөлгөөний, мөн зорчигчийн аюулгүй байдлыг ханган ажиллана.

3.3. Нийтийн таксийн үйлчилгээ

Тээвэрлэгч нь дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

3.3.1. Нийтийн таксийн үйлчилгээ нь “Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS5122:2013 Монгол Улсын стандартад тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна.

3.3.2. Такси үйлчилгээ нь тогтоосон чиглэл, цагийн хуваарь харгалзахгүй, зөвхөн **хотын дотор, хот орчимд, мөн аймаг, сумдын төвд үйлчилнэ.**

3.3.4. Нийтийн таксийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь

тээвэрлэлтийн гэрээний дагуу зорчигчдод үйлчилнэ.

3.3.5. Нийтийн таксийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын тээврийн хэрэгсэл зөвхөн өөрийн өмчлөлд байх бөгөөд бүртгэлийн нэгдсэн системд оруулсан байна.

3.3.6. Нийтийн таксийн үйлчилгээнд **тансаг зэрэглэлийн ба энгийн таксийг ажиллуулна. Тансаг зэрэглэлийн такси хар өнгөтэй, энгийн такси шар өнгөтэй байна.**

3.3.8. Нийтийн таксийн үйлчилгээний захиалгыг дуудлагын төвөөр дамжуулан авч, үйлчилнэ. Таксийн үйлчилгээний дуудлагын төвийг дангаар буюу тээвэрлэгч байгууллагыг түшиглэн ажиллуулж болно.

3.3.9. Таксийн үйлчилгээний дуудлагын төв нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.3.9.1. дуудлагын төв нь тээвэр зохион байгуулалт хариуцсан мэргэжлийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан ажиллана.

3.3.9.2. дуудлагын төв нь тээвэр зохион байгуулалт хариуцсан мэргэжлийн байгууллагаас таксийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан тээвэрлэгч, жолооч нартай гэрээ байгуулан ажиллана.

3.3.9.3. **дуудлагын төв нь тээвэр зохион байгуулалт хариуцсан мэргэжлийн байгууллагаас таксийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл аваагүй, дурын програм хангамж ашиглан таксийн үйлчилгээг хууль бусаар зохион байгуулж буй этгээдэд үйлчлэхгүй.**

3.3.9.4. дуудлагын төвийн үйлчилгээний 80 хувьд нь таксийн үйлчилгээний дуудлагыг хүлээн авах, жолооч, хэрэглэгчид хүргэх ба үлдсэн 20 хувьд нь **ачаа, бараа хүргэлтийн үйлчилгээ**, дуудлагын жолоочийн үйлчилгээг эрхэлж болно.

3.3.9.5. дуудлагын төв нь лавлах үйлчилгээ эрхлэхгүй.

3.3.9.6. дуудлагын үйлчилгээг хүлээн авах, мэдээлэх олон улсын жишигт нийцсэн харилцаа холбоо, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх ба өөрийн байртай байна.

3.3.9.7. дуудлагын төвд дуудлага хүлээн авах, жолооч, хэрэглэгчид хүргэх зэрэг үйлчилгээг хангах үүрэг бүхий операторууд ажиллана. Такси дуудлагын үйлчилгээ авах үйлчлүүлэгч нь оператор хандан захиалга өгөх ба оператор нь жолоочид очих газрын байршил, цаг хугацааг тодорхой өгсний дараа үйлчлүүлэгчид мэдэгдэнэ.

3.3.9.8. дуудлагын үйлчилгээг хангах олон улсын жишигт нийцсэн програм хангамжтай байна.

3.3.9.9. дуудлагын үйлчилгээнд ашиглаж буй програм хангамжийн талаарх мэдээллийг тээвэр зохион байгуулалт хариуцсан мэргэжлийн эрх бүхий байгууллагатай хийсэн гэрээнд нарийвчлан тусгаж, програм хангамжийн **аюулгүй байдал, нууцлалыг хамгаалан ажиллана.**

3.3.9.10. **Нийтийн таксийн үйлчилгээнд хэд хэдэн програм хангамжийг ашиглаж болох хэдий ч эдгээр програм хангамж нь зөвхөн нэг платформ дээр суурилах замаар нийтийн таксийн үйлчилгээний нэгдсэн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.**

3.3.10. Нийтийн таксийн үйлчилгээний тээврийн хэрэгсэлд төлбөрийн баримт

хэвлэгдэн гарах төхөөрөмж болон тоолуураар бүрэн тоногдсон байх ба **Стандарт хэмжил зүйн газраас жил бүр баталгаажсан** байна.

3.3.11. Зөвхөн таксины тоолуурт заасан заалт, баримтыг үндэслэн зорчигч үйлчилгээний хөлсийг төлөх бөгөөд тээш тээвэрлэсний хөлсийг давхардуулан төлөхгүй.

3.3.12. Такси дуудлагын хүлээлгийн хугацаа, төлбөр нь тоолуурын заалтаар гарах бөгөөд төлбөрийг заалтын дагуу зорчигч төлнө. Хүлээлгийн хугацааны төлбөр нь 1 километр зорчих төлбөрөөс бага байна.

3.3.13. Нийтийн таксийн үйлчилгээний жолооч нь дараах үүрэгтэй. Үүнд:

3.3.13.1. энэхүү дүрмийн 3.2.5 дахь заалтыг бүрэн хангаж ажиллана.

3.3.13.2. үйлчилгээний явцад зорчигч болон түүний тээшийн аюулгүй байдлыг ханган ажиллана.

3.3.13.3. зорчигчийг хүргэхдээ аль болох дөт замыг сонгон явна.

3.4. Жуулчин тээврийн үйлчилгээ

3.4.1. **Тээвэр зохион байгуулалт хариуцсан мэргэжлийн эрх бүхий байгууллагад** бүртгүүлж, тээвэрлэлтийн гэрээ байгуулснаар жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулна.

3.4.3. “Жуулчны автотээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5231:2003 Монгол Улсын үндэсний стандартад тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна.

3.4.4. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан Аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох журмын дагуу ангилал тогтоолгосон байгууллага, иргэн жуулчин тээвэрлэлтийг эрхлэн гүйцэтгэнэ.

3.4.5. Жуулчин тээврийн үйлчилгээг жуулчдын аяллын хөтөлбөрийн дагуу гүйцэтгэнэ.

3.4.6. Жуулчин тээврийн чиглэлийг тогтоох, чиглэлийн зураглалыг аялал жуулчлалын байгууллагын жуулчны хөтөлбөрт нийцүүлэн тухайн жуулчны үйлчилгээний байгууллага тогтооно.

3.4.7.6. Дараах нэмэлт шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллага нь жуулчин тээврийн үйлчилгээг эрхэлнэ. Үүнд:

3.4.7.1. эрх бүхий байгууллагаас тогтоосон ангиллын хүрээнд тээвэрлэлтийг гүйцэтгэх;

3.4.7.2. аялал жуулчлалын байгууллагын захиалга, гадаадын жуулчны хүсэлтээр автотээврийн хэрэгслийг сонгож, үйлчилгээг авахыг хүссэн тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулсан байх;

3.4.7.3. тээвэрлэлтийн явцад байнгын мэдээлэл, холбоотой ажиллах, шаардлагатай тохиолдолд техникийн түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;

3.4.7.4. жуулчин тээвэрлэлтэд ажиллах жолооч нарыг эрүүл мэнд, нийгмийн даатгалд бүрэн хамруулах, жолооч нэг бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах;

3.4.7.5. тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах үүднээс тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэл болон жолоочийн бэлэн байдлыг шалгасан баримтыг бүрдүүлэх, аяллын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгсөн байх.

3.4.8. Жуулчин тээврийн үйлчилгээнд ажиллах жолооч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.4.8.1. энэхүү дүрмийн 3.2.5 дахь заалтыг бүрэн хангаж ажиллана.

3.4.8.2. гадаад хэлний зохих мэдлэгтэй байх ба шаардлагатай тохиолдолд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг, чадвартай байх;

3.4.8.2. жуулчдыг суудалдаа бүрэн суусны дараа аялал эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгыг хөтөчийн тусламжтайгаар өгөх;

3.4.8.3. жуулчин тээвэрт хөтөчгүйгээр тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно.

3.5. Захиалгат үйлчилгээ

А. Хүүхэд тээвэрлэх үйлчилгээ

3.5.1. Хүүхэд тээвэрлэх үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж байгууллага нь хүүхдийг тээвэрлэх тээвэрлэлтийн чиглэл, чиглэлийн зураглал, автотээврийн хэрэгслийн тоо, улсын дугаар, жолоочийн нэр, байгууллагын үйл ажиллагааны товч танилцуулга зэргийг тээвэр зохион байгуулалт хариуцсан мэргэжлийн эрх бүхий байгууллагад албан хүсэлтээ тавьж, бүртгүүлнэ.

3.5.2. Хүүхэд тээвэрлэх үйлчилгээг Иргэний хуулийн 35 дугаар бүлгийн 381 дүгээр зүйлд заасны дагуу тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

3.5.3. Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан зааврын дагуу **хүүхэд тээвэрлэлтийн үед ажиллах зохион байгуулагч, туслах зохион байгуулагч, хүүхэд болон эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, тавигдах шаардлагыг хангана.** ерөнхий боловсролын тусгай дунд сургуулийн хүүхдийн автобусанд тавигдах нэмэлт шаардлагыг тээвэрлэлтийн гэрээнд тусгасан байна.

3.5.4. Тээвэрлэлтийн явцад хүүхдүүдэд зөвлөмж, зааварчилгаа өгөх, хяналт тавих, хүүхдэд туслах үүрэг бүхий насанд хүрсэн хүн ажиллана.

3.5.5. Хүүхэд тээвэрлэх үйлчилгээнд ажиллах жолооч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.5.5.1. энэхүү дүрмийн 3 дугаар бүлгийн 3.2.5 дахь заалтыг бүрэн хангаж ажиллана.

3.5.5.2. Хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч нь хөдөлмөр амралтын дэглэмийг мөрдөх ба автобусанд суудлын тооноос илүү хүүхэд тээвэрлэх, зорчигчийн танхимд хүүхэд байх үед автобусыг эзгүй орхих, автобусыг хүүхэд суулгах, буулгах газраас өөр газар зогсоох, хөдөлгөөний үед огцом тоормослох, тамхи татах, хөдөлгөөнд оролцох үедээ гар утсаар ярих зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.

3.5.5.3. тээвэрлэлтийн гэрээгээр тогтоосон чиглэл, чиглэлийн дагуух зогсоол болон цагийн хуваарийн дагуу тээвэрлэлтийг гүйцэтгэх ба автобусны техникийн хурдыг цагт 50 километрээс хэтрүүлэхгүйгээр хөдөлгөөнд оролцоно.

3.5.5.4. Хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч нь хөдөлгөөнд

оролцох үед техникийн эвдрэл саатал гарсан нэн даруй холбогдох байгууллагад мэдэгдэж, дараагийн автобус иртэл хүүхдийг автобуснаас буулгахгүй байна.

3.5.5.5. Хөдөлгөөн эхлэхийн өмнө тээвэрлэлтийн аюулгүй байдлын зааварчилгаа өгөх, хүүхэд болон зохион байгуулагчийн үүргийг танилцуулах, жолооч, зохион байгуулагч нар хүүхэд автобуснаас суух, буух үед хяналт тавьж ажиллана.

3.5.5.6. Хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгсэл дотор замналын зураг болон бусад санамжуудыг зохих стандартын дагуу бичиж байрлуулсан байх ба автобусаар зөвхөн хүүхэд тээвэрлэнэ.

Б. Ажилчдыг тээвэрлэх үйлчилгээ ба бусад захиалгат үйлчилгээ

3.5.6. Ажилчдыг тээвэрлэх үйлчилгээ ба бусад захиалгат үйлчилгээг эрхлэх аж ахуйн нэгж байгууллага нь тээвэрлэлтийн чиглэл, чиглэлийн зураглал, автотээврийн хэрэгслийн тоо, улсын дугаар, жолоочийн нэр, байгууллагын үйл ажиллагааны товч танилцуулга зэргийг тээвэр зохион байгуулалт хариуцсан мэргэжлийн эрх бүхий байгууллагад албан хүсэлтээ тавьж, бүртгүүлнэ.

3.5.7. Тээвэр зохион байгуулалт хариуцсан мэргэжлийн эрх бүхий байгууллага нь ажилчдыг тээвэрлэх үйлчилгээ ба бусад захиалгат үйлчилгээг эрхлэх аж ахуйн нэгжтэй Иргэний хуулийн 35 дугаар бүлгийн 381 дүгээр зүйлд заасны дагуу тээвэрлэлтийн гэрээг байгуулж, гэрээний дагуу зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.5.8. Тээвэр зохион байгуулалт хариуцсан мэргэжлийн эрх бүхий байгууллага нь иргэн, байгууллагын захиалгыг албан бичгээр болон утсаар хүлээн авч бүртгэх ба захиалгын дагуу тээвэрлэлтийг зохион байгуулна.

3.5.9. Ажилчдыг тээвэрлэж байгаа болон бусад захиалгат үйлчилгээнд ажиллаж буй жолооч нь энэхүү дүрмийн 3 дугаар бүлгийн 3.2.5 дахь заалтыг бүрэн хангаж ажиллана.

Дөрөвдүгээр бүлэг. Тээвэрлэлтийн гэрээ

4.1. Тээвэрлэлтийн гэрээнд дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

4.1.1. тээвэрлэгчийн эрх;

4.1.2. тээвэрлэгчийн үүрэг;

4.1.3. тээвэрлүүлэгчийн эрх;

4.1.4. тээвэрлүүлэгчийн үүрэг;

4.1.5. тээвэрлэлтийн талаар талуудын хүлээх хариуцлага

4.1.6. ачаа, тээш, **илгээмжийн ачааг** хүлээн авах, тээвэрлэх, олгох үйл ажиллагаа;

4.1.7. зорчигчийн аюулгүй байдал;

4.1.8. зорчигчийн гар тээш, тээш, илгээмжийн ачааны аюулгүй байдал;

4.1.9. тээвэрлэлтийн чиглэл;

4.1.10. тээвэрлэлтийн замнал;

- 4.1.11. тээвэрлэлтийн цагийн хуваарь;
- 4.1.12. тээврийн хөлс;
- 4.1.13. суудал захиалга, захиалгыг баталгаажуулах, захиалгыг цуцлах;
- 4.1.14. тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой технологийн карт, зааварчилгаа;
- 4.1.15. тээвэрлэлтээс татгалзах, түр зогсоох, цуцлах нөхцөл;
- 4.1.16. гомдол, нэхэмжлэл гаргах нөхцөл, хугацаа;

Зорчигч тээврийн дэд бүтэц

3.7. Зорчигч тээврийн үйл ажиллагааг дараах дэд бүтцийн байгууламжуудаар дамжуулан гүйцэтгэнэ.

- 3.7.1. зорчигч тээврийн автобуудал;
- 3.7.2. зорчигч тээврийн терминал;
- 3.7.3. авто замын дагуух үйлчилгээний байгууламж.

Тавдугаар бүлэг. Зорчигч тээврийн хөлс, хөнгөлөлт, нөхөн олговор, тасалбар түгээлт, буцаан олголт

5.1. Зорчигч нь тээврийн хөлсийг дараах байдлаар төлнө.

- 5.1.1. бэлнээр;
- 5.1.2. цахимаар;
- 5.1.3. картаар;
- 5.1.4. бусад.

5.2. Зорчигч тээврийн үйлчилгээний төлбөрийн цахим систем улсын хэмжээнд нэгдмэл байна.

5.3. Зорчигч тээврийн үйлчилгээний тээврийн хөлсийг 30 хоног, 90 хоног, 365 хоногийн өмнө урьдчилан төлөх боломжтой байх бөгөөд урьдчилан төлсөн тохиолдолд төлбөрийн 5-30 хүртэлх хувийн хөнгөлөлтийг эдэлнэ.

5.4. Нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр зорчих тасалбар нь тээвэрлэгч, зорчигч хоёрын хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох бичиг баримт болно.

5.5. Хотын доторхи болон хот орчим, аймгийн төвийн доторхи нийтийн тээврийн үйлчилгээнд тээврийн хөлсийг төлөхдөө бэлэн мөнгө ашиглахгүй.

5.6. Улс, хот хоорондын зорчигч тээврийн хөлсийг “Автотээврийн жишиг тариф шинэчлэн батлах тухай” Зам тээврийн сайдын 2013 оны 162 дугаар тушаалд нийцүүлэн тээвэрлэлтийн гэрээгээр тогтооно.

5.7. Хотын доторхи болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн хөлсийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тогтооно.

5.8. Жуулчин болон захиалгат тээврийн хөлсийг тээвэрлэгч, тээвэрлүүлэгч хоорондын тээвэрлэлтийн гэрээгээр зохицуулна.

5.9. Аймаг, нийслэлийн доторх нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр зорчихдоо Автотээврийн тухай, Боловсролын тухай, **Ахмад настны тухай**, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай”, **Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай** хуулийн хэрэгжилтийг тус тус хангана.

5.10. Аймаг, нийслэлийн доторх нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр зорчих иргэдийн нөхөх олговор олгох журам, нөхөх олговрын төсвийг **Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн дагуу аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.**

5.11. **Хотын доторхи болон хот орчим, аймгийн төвд нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр /таксианаас бусад/ 0-11 насны хүүхдийг үнэ төлбөргүй тээвэрлэнэ.**

5.13. **Улс, хот хооронд, орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээнд 0-6 насны хүүхдийг үнэ төлбөргүй, 6-аас дээш насны хүүхдийг хөнгөлөлттэй үнээр тээвэрлэнэ.**

5.14. Нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр харааны бэрхшээлтэй иргэдийн хөтөч нохойг үнэ төлбөргүй тээвэрлэнэ.

5.15. Улс, хот хооронд, аймаг, нийслэл, орон нутгийн нийтийн тээврийн үйлчилгээний зорчих тасалбар (төлбөрийн цахим карт)-ыг иргэдийн эрэлтэд нийцүүлж авто буудал, зорчигчийн терминал, автобусны зогсоол болон худалдаа үйлчилгээний төв, бусад газруудад худалдаалах, цэнэглэх эсхүл цахим шуудангаар урьдчилан худалдах зэргээр зохион байгуулна.

5.16. **Улс, хот хооронд, орон нутгийн зорчигч** тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгсэлд сул суудал байгаа тохиолдолд энэ талаарх мэдээллийг хүлээн авсны үндсэн дээр тухайн чиглэлийн дагуух дундын зогсоол дээр зорчигчдод зорчих тасалбар бичиж үйлчилж болно.

5.17. **Улс, хот хооронд, орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээнд** тасалбар худалдаалах үйл ажиллагааг автобус хөдлөхөөс 5 минутын өмнө зогсооно. Тасалбар худалдаалах газрын байршлаас хамаарч авто буудлын дарга энэхүү хугацааг өөрчилж болно.

5.18. **Улс, хот хооронд, орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээний хуваарьт** тээврийн хэрэгсэл хөдлөхөөс 4-өөс доошгүй цагийн өмнө зорчигч урьдчилан худалдан авсан зорчих тасалбарыг буцаах бол тасалбарын үнийг бүрэн эргүүлж авах, харин энэ хугацаанаас хожуу буюу хуваарьт тээврийн хэрэгсэл хөдлөхөөс өмнө тасалбараа буцаах бол тээвэрлэгчээс тогтоосон үйлчилгээний хөлсийг суутган, тасалбарын үнийг эргүүлэн авч болно.

5.19. **Улс, хот хооронд, орон нутгийн зорчигч** тээврийн үйлчилгээгээр үйлчлүүлэхээр тасалбар худалдан авсан зорчигч нь хуваарьт цагаас хоцорсон бол 8 цагийн дотор тээвэрлэгчээс тогтоосон үйлчилгээний хөлсийг нэмж төлөн дараагийн хуваарьт тээврийн хэрэгслээр зорчих эсхүл тээвэрлэгчээс тогтоосон үйлчилгээний хөлсийг суутган, зорчих тасалбарын үнийн үлдсэн хэсгийг буцаан авч болно.

5.20. Хэрэв зорчигч нь замдаа өвчлөх зэрэг хүндэтгэх шалтгаанаар цааш явж чадахгүйд хүрвэл замын үлдсэн зайд ногдох зардлыг буцаан авах бөгөөд тээвэрлэгчээс тогтоосон үйлчилгээний хөлсийг нэгэн адил төлнө.

5.21. Хүндэтгэх шалтгааны улмаас зорчигч аяллаа үргэлжлүүлэхгүйгээр шийдсэн бол худалдан авсан зорчих тасалбараа буцааж, мөнгөө эргүүлэн авч болно.

5.22. Улс, хот хооронд, орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээнд зорчигч нь замдаа өвчлөхээрэг хүндэтгэх шалтгаанаар аяллаа цааш үргэлжлүүлж чадахгүйд хүрвэл замын үлдсэн хэсэгт ногдох зардлыг зорчигчид буцаан олгоно.

5.23. Улс, хот хооронд, орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээнд зорчигч тасалбараа үрэгдүүлсэн, гээгдүүлсэн тохиолдолд тасалбар худалдан авсан зорчигчийн талаарх мэдээлэл тасалбар түгээлтийн мэдээллийн санд бүртгэгдсэн эсэхийг баталсны үндсэн дээр иргэний биеийн байцаалттай тулган тасалбарын үнийг дахин төлүүлэхгүйгээр тасалбар нөхөн олгохтой холбоотой үйлчилгээний нэмэлт хураамжийг төлүүлэн, зорчигчид зорчих тасалбарыг нөхөн олгож болно.

5.24. Улс, хот хооронд, орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээнд зорчих тасалбарт нэр нь бичигдсэн зорчигч уг тасалбараар үйлчлүүлнэ. Аяллын дундуур зорчих тасалбарыг дур мэдэн бусдад шилжүүлэхгүй ба хэрэв шилжүүлсэн бол хүчингүйд тооцно.

5.25. Зорчих тасалбар түгээлтийн цэг нь доорхи тохиолдолд зорчих тасалбар худалдахаас татгалзах эрхтэй:

5.25.1. нийтийн зорчигч тээврийн хэрэгсэлд сул суудал байхгүй;

5.25.2. иргэний үнэмлэх эсхүл бусад биеийн байцаалтгүй;

5.25.3. асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй дараах этгээд:

- 0-11 насны хүүхэд;
- хүнд өвчтэй зорчигч;
- согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн этгээд;

5.26. тээвэр зохион байгуулалт хариуцсан байгууллагын шаардлагаар батлагдсан хувиараас гадуур зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг нэмэлтээр зохион байгуулсан тохиолдолд авто буудлаар үйлчилсэн, тасалбар түгээсэнтэй холбоотой үйлчилгээний хураамжаас тээвэрлэгчийг чөлөөлнө.

Зургаадугаар бүлэг. Зорчигчийн гар тээш, тээш, илгээмжийн ачааг хүлээн авах, бүртгэх, хадгалах, тээвэрлэх, олгох

6.1. Автобуудал болон авто замын дагуух үйлчилгээний байгууламж нь ачаа, тээш хүлээн авах, хадгалах, олгох стандартын шаардлага хангасан тусгайлсан байртай байна. Уг байраар дамжуулан дараах ачааг хүлээн авах, бүртгэх, хадгалах, тээвэрлэх, хүлээн авагчид олгох үйлчилгээг зохицуулна. Үүнд:

- 1) зорчигчийн гар тээш;
- 2) зорчигийн тээш;
- 3) илгээмжийн ачаа.

6.2. Ачаа, тээш хүлээн авах, хадгалах, олгох байрны ажиллах цагийн хуваарь, ачаа, тээш хүлээн авах, хадгалах нөхцөл шаардлагын талаарх мэдээллийг нийтэд үзэгдэхүйц газарт байрлуулна.

6.3. Ачаа, тээшийг зорчигч болон илгээгчээс хүлээн авах, бүртгэх, тээвэрлэлтэд бэлтгэх, хүлээн авагчид олгохдоо QR болон зураасан код зэрэг үйлчилгээний хялбаршуулсан нөхцөл, дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжийг ашиглана.

6.4. Ачаа, тээшийг хүлээн авах, хадгалах, олгохдоо зорчигч, иргэдийн биеийн

байцаалтыг үндэслэн сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг шалгаж, холбогдох бичиг баримтыг үйлдэнэ. Ачаа, тээшийг хүлээн авч, ачааны дагалдах хуудсыг төлбөрийн баримт хамтаар зорчигч болон илгээгчид олгоно.

6.5. Гар тээш тээвэрлэх:

6.5.1. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч нь 60х40х20 см-ээс илүүгүй овор хэмжээтэй 15 кг хүртэл жинтэй, улс хоорондын тээвэрлэлтэд 20 кг хүртэл жинтэй тээшийг гар тээшийн хамт үнэ төлбөргүй тээвэрлэнэ.

6.5.2. Гар тээш нь сав, баглаа, боодлын байдлаас үл хамааран хэмжээгээр автобусны доторхи гар тээшний байранд хялбар багтах, бусад зорчигчдод саад болохооргүй байна.

6.5.3. Гар тээшинд зорчигчийн аяллын туршид хэрэглэх хүнсний болон хувийн хэрэгцээний эд зүйлс, ариун цэврийн хэрэглэл, ахуйн зориулалттай бараа орно.

6.5.4. Гар тээшний бүрэн бүтэн байдлыг зорчигч өөрөө хариуцна.

6.5.5. Автобус болон бусад зорчигчийн эд зүйлсийг гэмтээх, бохирдуулах, эвгүй үнэртэй, хорт ачаа, галт зэвсэг, галын аюултай, түргэн ба өөрөө шатах, тэсрэх, дэлбэрэх, цацраг идэвхит, идэмхий болон хордуулах бодис зэрэг хууль тогтоомжоор тээвэрлэхийг хориглосон эд юмсыг гар тээшинд авч явахыг хориглоно.

6.5.7. Гар тээшийг хадгалуулахдаа зохих хөлсийг тогтоосон тарифын дагуу төлнө. Гар тээшин дэх түргэн муудах, гэмтэх эд зүйлсийг **автотээврийн байгууллага** хариуцахгүй.

6.6. Зорчигчийн тээш хүлээн авах ба тээвэрлэх

6.6.1. Бүх автобуудлууд болон авто замын дагуух үйлчилгээний байгууламжинд зорчигчийн тээш хүлээн авах, бүртгэх, тээвэрлэх, хадгалах, олгох үйл ажиллагаа явагдана.

6.6.2. Зорчигчийн тээшийг хүлээн авах, хадгалах, тээвэрлэх, олгох үйлчилгээг зорчигчийн терминал, автобуудал, авто замын дагуух үйлчилгээний байгууламжуудаар дамжуулан зохицуулна.

6.6.3. Зорчигчоос хүлээн авах тээш нь автобусны ачааны хэсэгт чөлөөтэй багтах, ачих, буулгах, зөөвөрлөхөд хялбар бариултай, сав, баглаа, боодол нь тээвэрлэлтийн явцад тээшийн бүрэн бүтэн байдлыг найдвартай хангахаар зохих дүрэм, журам, зааврын дагуу бэлтгэгдсэн байвал зохино.

6.6.4. Зорчигчийн тээшийн сав, баглаа, боодол нь бат бэх, цоож нь гэмтэлгүй байх шаардлагыг хангасан байна.

6.6.5. Нэг байр эзлэх тээш нь ... кг-аас ихгүй байх ба нэг зорчих тасалбараар тээвэрлүүлэх тээшний нийт хэмжээ ... кг-аас ихгүй байна. Зорчигч нь энэхүү хэмжээнээс хэтэрсэн тээш авч явбал тогтоосон тарифын дагуу ачааны хөлсийг төлнө.

6.6.6. Бүрэн бүтэн бус сав, баглаа, боодолтой тээшийг тээвэрлэлтэд хүлээн авахгүй. Бусад тээшинд гэм хор учруулах, бохирдуулах, эвгүй үнэртэй, хорт ачаа, галт зэвсэг, галын аюултай, түргэн ба өөрөө шатах, тэсрэх, дэлбэрэх, цацраг идэвхит, идэмхий болон хордуулах бодис зэрэг хууль тогтоомжоор тээвэрлэхийг хориглосон зүйлс, түүнчлэн тэжээвэр болон ан амьтан, шувуу авч явахыг хориглоно.

6.6.7. Зорчигчийн зорчих тасалбарт заасан эцсийн цэг хүртэл тээшийг тээвэрлэх ба хүлээн авах цэгийн байршлаас хамаарч автобус хөдлөхөөс нэг цагаас доошгүй хугацааны өмнө тээшийг тээвэрлэлтэд хүлээн авна.

6.6.8. Улс, хот хооронд, орон нутгийн зорчигч тээвэрлэлтэд зорчигчийн тээшийг тухайн зорчигчийг тээвэрлэж буй автобусаар тээвэрлэнэ. Тээшийг шилжүүлэн ачилт бүхий чиглэлээр явуулсан тохиолдолд түүний хүргэх хугацааг нийтийн зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөний цагийн хуваарьт нийцүүлэн тогтооно.

6.6.9. Тээшийн сав баглаа, боодол нь тухайн эд зүйлийн аюулгүй тээвэрлэх шаардлагыг хангасан байх, ачилтын үед ачааны бүрэн бүтэн байдлыг хангахуйц байвал зохино. Хагарч эвдрэх эд зүйлс бүхий тээшинд тухайлсан тэмдэг наах ба ийм наалт бүхий ачаа, тээшийг анхаарал болгоомжтой тээвэрлэх үүргийг тээвэрлэгч хариуцана.

6.6.10. Тээвэрлэлтийн явцад тээшний бүрэн бүтэн, аюулгүй байдлыг тээвэрлэгч хариуцана.

6.6.11. Улс, хот хооронд, орон нутгийн тээвэрлэлтэд нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр зорчигчийн авч яваа 0-2 насны нялх хүүхдийн хэрэглэж буй хүүхдийн тэрэг, хөлд оруулагч зэрэг шаардлагатай зүйлс, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргэнцэрийг үнэ төлбөргүй тээвэрлэнэ.

6.6.12. Тээшийн хүндийн жин ачааны дагалдах бичигт зааснаас илүү байвал аяллын замд ба хүрэх газрын автобуудал, зорчигчийн терминал, авто замын дагуух үйлчилгээний байгууламжид акт үйлдэн, тээврийн хөлсний зөрүүг зорчигчоос шаардаж авна.

6.6.13. Зорчигч тээшийг хадгалуулахдаа тогтоосон тарифын дагуу зохих хөлсийг төлнө.

6.6.14. Зорчигч тээшний тасалбарыг зорчигчийн тасалбараас тусад нь олгох, уг тээшний тасалбарыг үндэслэн ачааг олгоно. Хэрэв зорчигч тээшний тасалбарыг гээгдүүлсэн үед тээшийг хүлээн авах эрх бүхий этгээд мөн гэдгийг баталсан хангалттай нотлох баримтыг бүрдүүлсний үндсэн дээр тухайн иргэнд тээшийг олгоно.

6.7. Илгээмжийн ачааг хүлээн авах ба тээвэрлэх

6.7.1. Бүх автобуудлууд болон авто замын дагуух үйлчилгээний байгууламжинд илгээмжийн ачааг хүлээн авах, бүртгэх, тээвэрлэх, хадгалах, олгох үйл ажиллагаа явагдана.

6.7.2. Илгээмжийн ачааг хүлээн авах, хадгалах, тээвэрлэх, олгох үйлчилгээг зорчигчийн терминал, автобуудал, авто замын дагуух үйлчилгээний байгууламжуудаар дамжуулан зохицуулна.

6.7.3. Илгээмжийн ачааг нийтийн зорчигч тээврийн хэрэгслийн жолооч хүлээн авахыг хориглоно.

6.7.4. Илгээмжийн ачаа нь сав, баглаа, боодол нь тэдгээрийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн нөхцлийг хангасан байна. Хагарч эвдрэх ачаанд тухайлсан тэмдэг наах ба ийм наалт бүхий ачааг анхаарал болгоомжтой тээвэрлэх үүргийг тээвэрлэгч хариуцана.

6.7.5. Нэг байр эзлэх илгээмжийн ачааны хүндийн жин ... кг-аас ихгүй байх ба гурвалсан хэмжээсийн нийлбэр ... см-ээс ихгүй байна. Энэхүү хэмжээнээс хэтэрсэн илгээмжийн ачааг тээвэрлэлтэд авахгүй.

6.7.6. Тээвэрлэлтийн явцад ачааны бүрэн бүтэн, аюулгүй байдлыг тээвэрлэгч хариуцана.

6.7.7. Дараах илгээмжийн ачааг эхний ээлжинд тээвэрлэнэ. Үүнд:

- 1) сонин, бусад өдөр тутмын тогтмол хэвлэл;
- 2) албан бичиг, бичиг баримт;
- 3) эм тариа, эмнэлгийн бүтээгдэхүүн;
- 4) бага насны хүүхдийн эд зүйлс;
- 5) түргэн гэмтэж, муудах бүтээгдэхүүн;
- 6) эд хогшил (замдаа шилжүүлэн ачилттай хүлээн авч болно.).

6.7.8. Илгээмжийн ачааг замаас дахин илгээх болон замд тавьж олгохыг хориглоно.

6.7.9. Илгээмжийн ачааг автотээврийн байгууллага 24 цагаас дээш хадгалахгүй.

6.7.10. Түргэн гэмтэж муудах илгээмжийн ачаа тогтоосон хугацаанд хүргэгдсэн боловч тээвэрлэлтээс үл хамаарах шалтгаанаар шинж чанар нь муудсан тохиолдолд тээвэрлэгч гэм буруугүй болохоо нотолж, хариуцлагаас чөлөөлөгдөнө.

6.7.11. Илгээмжийн ачааг хүрэх газарт хүрмэгц ачаа хүлээн авагч нь шалгаж, хүлээн авах ба харилцаа холбооны хэрэгслээр хүлээн авагчид мэдэгдэн, биеийн байцаалт ба ачааны дагалдах бичиг баримтыг тулган үзсэний үндсэн дээр ачааг олгоно.

6.8. Ачаа, тээш үрэгдэх:

6.8.1. Хадгалуулахаар өгсөн гар тээш, тээш, илгээмжийн ачаа үрэгдвэл автобуудал болон авто замын дагуух үйлчилгээний байгууламжийн дарга тэмдэглэл үйлдэж, тээш хадгалуулсан эзэнд хохирлыг барагдуулна. Барагдуулсан хохирлыг иргэн хүлээн зөвшөөрөхгүй бол хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

6.8.2. Алдагдсанд тооцсон гар тээш, тээш, илгээмжийн ачаа олдвол өмнө нь эзэнд нь төлсөн төлбөрөө эргүүлэн авч, гар тээш, тээшийг олгоно.

6.8.3. Гар тээш, тээш, илгээмжийн ачаа хадгалуулсан баримтыг зорчигч, иргэн нь үрэгдүүлсэн тохиолдолд өөрийн эд зүйл болохыг нотолсон баримт бичгийг бүрдүүлэх бөгөөд түүнийг хянан үзсэний үндсэн дээр олгож болно. Бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг тээвэрлэгч өөрийн дотоод журмаар зохицуулна.

6.8.4. Илгээмжийн ачаанаас бусад зорчигийн гар тээш, тээшийг 5 хүртэлх хоногийн хугацаатайгаар хадгалах байранд хүлээн авна. Ачаа, тээшээ 30 хоногийн дотор авахгүй тохиолдолд мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгөх ба

автотээврийн байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран комиссыг томилж, уг гар тээш, тээш, илгээмжийн ачааг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан борлуулж, хадгалалтын гэрээний хөлсийг нөхөн төлүүлнэ.

6.8.5. Зорчигч тээврийн хэрэгслээр зорчигчдын амь нас, эрүүл мэндэд аюул хохирол учруулж болзошгүй, мөн тэдний хувцас, эд зүйл, автотээврийн хэрэгслийг бохирдуулах буюу гэмтээж болзошгүй, хурц үзүүр, иртэй зүйл, галын аюултай, тэсэрч дэлбэрэх, идэмхий болон хордуулах бодис, буу зэвсэг авч явахыг хориглоно.

6.8.6. Нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр /таксинаас бусад/ гэрийн тэжээвэр амьтан, шувуу, ан амьтан тээвэрлэхийг хориглоно.

Долдугаар бүлэг. Зорчигч тээврийн үйлчилгээний даатгал, аюулгүй байдал

7.1. Тээвэрлэгч нь зорчигчийн амь нас, эрүүл мэнд болон тээшинд учирч болзошгүй хохирлыг хариуцах зорилгоор Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Автотээврийн тухай хуультай нийцүүлэн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

7.2. Улс хооронд, хот хооронд, аймаг хооронд, орон нутгийн нийтийн тээвэр, жуулчин тээвэр, **захиалгат** үйлчилгээгээр үйлчлүүлж буй зорчигч нь өөрийн амь нас, эрүүл мэнд, тээшийг албан журмын даатгалд заавал даатгуулсан байна.

Наймдугаар бүлэг. Зорчигч тээврийн үйлчилгээний хяналт шалгалт, гомдол шийдвэрлэх

8.1. Зорчигч тээврийн үйлчилгээтэй холбоотой тээвэрлэгч, тээвэрлүүлэгч болон зорчигчийн гомдол, санал, хүсэлтийг дараах байдлаар хүлээн авна.

8.1.1. биечлэн ирж мэдүүлэх;

8.1.2. утсаар мэдүүлэх;

8.1.3. албан бичиг, өргөдлөөр мэдүүлэх;

8.1.4. цахимаар мэдүүлэх.

8.2. Тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн болон тээврийн хэрэгслийн жолоочийн ёс зүй, үйлчилгээний доголдолтой холбоотой зорчигчийн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, хянан үзэж, 3-7 хоногийн дотор барагдуулна.

8.3. Зорчигч тээврийн үйлчилгээний зөрчил, дутагдлыг удаа дараа давтан гаргавал тухайн зорчигчийн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, хянан үзэж, 3-21 хоногийн дотор барагдуулна.

8.4. Зорчигчийн тээшхадгалалт, үрэгдүүлсэнтэй холбоотой гомдлыг хүлээн авч, хянан үзэж, үүссэн гомдлыг 7 хоногт барагдуулна.

8.5. Зорчигчийн гомдлын дагуу тээвэрлүүлэгч, тээвэрлэгч болон тээврийн хэрэгслийн жолооч, нарт автотээврийн хяналтын улсын байцаагч хариуцлага тооцож, энэ тухай зорчигчид хариу мэдэгдэнэ.

8.6. Автотээврийн хяналтын улсын байцаагч нь автобуудал, зорчигчийн терминал, авто замын дагуух үйлчилгээний байгууламж болон автобусанд тасалбар

түгээлт, ачаа хүлээн авалт, хадгалалт, олголтын үйл ажиллагаанд хяналт тавихын зэрэгцээ үйлчилгээнд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна.

Есдүгээр бүлэг. Зорчигч тээврийн үйлчилгээний мэдээлэл, удирдлага хяналтын нэгдсэн систем

9.1. Нийслэл, аймаг, орон нутгийн автотээврийн байгууллагууд нь зорчигч тээврийн үйлчилгээнд цахим мэдээлэл, удирдлага хяналтын нэгдсэн сүлжээнд холбогдсон байна.

9.2. Зорчигч тээврийн үйлчилгээний цахим мэдээлэл, удирдлага хяналтын нэгдсэн сүлжээ нь нэгдмэл байх ба үйл ажиллагааг удирдлага хяналтын нэгдсэн төв хэрэгжүүлнэ.

9.3. Мэдээллийн нэгдсэн системийн тусламжтайгаар зорчигч тээврийн үйлчилгээний мэдээллийг цуглуулан, бүртгэлжүүлнэ.

9.4. Удирдлага хяналтын нэгдсэн системийн тусламжтайгаар дараах үйл ажиллагааг зохицуулна.

9.4.1. тээврийн хэрэгслийн хөдөлгөөний зохицуулалт (автобуудал, авто замын дагуух үйлчилгээний байгууламж, зорчигчийн терминалаас явах, ирэх, тээвэрлэлтийн явцад))-ыг хийх, хянах;

9.4.2. тээврийн хэрэгслийн суудал ашиглалт, хөдөлгөөний цагийн хуваарийг хянах;

9.4.3. тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг хянах, аяллын туршид тээврийн хэрэгслийн хурдны мэдээллийг тээврийн хэрэгслийн жолооч нарт мэдээлэх, холбогдох арга хэмжээг авах;

9.4.4. тээврийн хэрэгслийн саатлыг хянах, мэдээлэх, холбогдох арга хэмжээг авах;

9.4.5. авто замын болон цаг агаарын нөхцөл байдал, тээврийн хэрэгслийн техникийн болон зорчигчдын аюулгүй байдал, тээвэрлэлтийн талаарх мэдээллийг тээврийн хэрэгслийн жолоочоос аяллын туршид 3 цаг тутамд авах;

9.4.6. тээврийн хэрэгслийн жолоочид зам тээврийн осол, саатлаас урьдчилан сэргийлэх тухай зөвлөмжийг аяллын туршид өгөх;

9.4.7. тээврийн хэрэгслийн жолооч аяллын замын дагууд зорчигч буух, суух тохиолдолд энэ талаарх мэдээллийг системийн ажилтанд тухай бүр мэдээлэх;

9.4.8. автотээврээр гүйцэтгэж буй жуулчин тээврийн үйлчилгээг хянах, шаардлагатай тохиолдолд урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр хангах;

9.5. Удирдлага хяналтын нэгдсэн төв нь зорчигч тээврийн үйлчилгээний мэдээлэл, үйл ажиллагааны тайланг сар тутам төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

Аравдугаар бүлэг. Дүрэм зорчигчдод хүлээх хариуцлага

10.1. Тээвэрлэгч, зорчигчийн хүлээх эрх, үүрэг

10.1.1. авто замаар зорчигч, гар тээш, тээш тээвэрлэх дүрмийг үндэслэн

автотээврийн байгууллага нь зорчигчийн өмнө, зорчигч нь автотээврийн байгууллагын өмнө харилцан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

10.1.1.1. автотээврийн байгууллагууд энэхүү дүрэмд заасан хэм хэмжээг баримтлан эрх үүргээ шударгаар хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

10.1.1.2. энэхүү дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн автотээврийн байгууллагын удирдлага, ажилтанд хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасанд тооцон, хөдөлмөрийн сахилгын шийтгэл ноогдуулах ба энэ нь хуульд зааснаас бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

10.1.1.3. энэхүү дүрмээр зохицуулсан харилцаанд оролцогч гадны байгууллага, иргэд, зорчигчтой холбоотой зөрчил, дутагдлыг энэ дүрэм болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

10.1.2. Автотээврийн байгууллага нь зорчигчийг ая тухтай зорчих нөхцлийг бүрдүүлж, зорьсон газарт нь цаг хугацаанд нь хүргэх үүрэгтэй.

10.1.3. Автотээврийн байгууллага нь зорчигчийн тээш ба **илгээмжийн ачааг** хүлээж авснаас эхлэн олгох хүртэл тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцана.

10.1.4. Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд Автотээврийн тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

10.1.5. Автотээврийн байгууллага нь тээвэрлэлтийн явцад тээш алдагдуулах, гэмтээх, тээш хүргэх хугацаа хожимдуулсны нөхөн төлбөрийг төлнө.

Арван нэгдүгээр бүлэг. Маргаан шийдвэрлэх

11.1. Олон нийтийн хэв журам сахих:

11.1.1. зорчигч нь автотээврийн хэрэгсэл болон автобуудлын эд хогшилд ариг гамтай хандан олон нийтийн хэв журмыг чанд сахиж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон автотээврийн байгууллагад мөрдөгдөж буй эрх зүйн бичиг баримт, дүрэм, журмыг биелүүлэх үүрэгтэй.

11.1.2. зорчигч нь энэхүү дүрмийн 11.1.1 дэх заалтыг зөрчвөл автобуудлын дарга, автотээврийн улсын байцаагч, цагдаагийн ажилтан асуудлыг шийдвэрлэнэ.

11.2. Маргааныг шийдвэрлэх:

11.2.1. албан үүргээ гүйцэтгэж буй автотээврийн байгууллагын ажилтан болон зорчигчийн хооронд гарсан маргаан, үл ойлголцлыг дараах байдлаар шийдвэрлэнэ:

11.2.1.1. автобуудлын дарга, автотээврийн улсын байцаагч, шаардлагатай бол цагдаагийн ажилтны тусламжтайгаар;

11.2.1.2. аяллын явцад тээврийн хэрэгслийн жолооч, тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллага, шаардлагатай бол харьяалах дээд шатны байгууллагын оролцоотойгоор.

11.2.2. үйлчилгээтэй холбоотой тухайн нөхцөлд шийдвэрлэх боломжгүй асуудлыг харьяалах дээд шатны байгууллагад нь хандаж шийдвэрлүүлнэ.

---oOo---